



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 4/319

Мандалговь

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.4.2 Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1, 2 дугаар зүйлийн 2.2, 2022 онд сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргаас Сумдын Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээний хавсралтаар батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг үндэслэн “А буюу Маш сайн”, “В буюу Сайн” үнэлэгдсэн сумдын Засаг дарга нарт хавсралтын дагуу мөнгөн урамшууллыг олгосугай.

2. Мөнгөн урамшууллыг үндсэн цалингаас тооцож байгууллагын төсөвтөө багтаан олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111075

Дундговь аймгийн Засаг даргын 2022  
оны 07 дугаар сарын 18-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ 2022 ОНД БАЙГУУЛСАН  
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭ

2022.06.10

Д/д	Сумдын нэр	СТСХ	ТЗУХ	ХЭЗХ	ХОХБТХ	НБХ	Үнэлгээ	Урамшуул лын хувь
1	Адаацаг	85.0	85,60	79.4	73.9	85	81.78	65.4
2	Баянжаргалан	77.0	80	81.1	74.4	68.4	76.18	-
3	Говь-Угтаал	94.7	86.2	70	67	60.9	75.76	-
4	Гурвансайхан	97.5	73	69.4	66.1	59.8	73.16	-
5	Дэрэн	90.0	70.58	81.25	65.3	57.4	72,91	-
6	Дэлгэрцогт	86.2	91.85	86.6	76.52	68.2	81.88	65.5
7	Дэлгэрхангай	97.8	62	58.75	68.9	71.1	71.71	-
8	Луус	95.1	86.49	80.5	67.6	63.6	78.66	-
9	Өлзийт	99.0	63.68	75	73	70.0	76.14	-
10	Өндөршил	97.6	72.21	68.75	68.3	69.8	75.34	-
11	Сайнцагаан	90.8	79.4	71.7	75	75.2	78.42	-
12	Сайхан-Овоо	86.1	73.35	85.5	70	43.5	71.69	-
13	Хулд	84.6	61.95	70	74.3	41.8	66.53	-
14	Цагаандэлгэр	88.9	71.93	81.1	64.7	72.8	75.89	-
15	Эрдэнэдалай	79.1	86.80	80	81.2	74.6	80.34	64.2
16	Дүн	90.0	76.34	81.27	71	65.5	75.84	